ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ханбогд сумын Оргилдоржшүг ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ӨМА-2024/21/НА-СТА-ОНА**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өмнөговь аймаг<br>2024 он | Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр<br>Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Т.Хонгорзул<br>Утас:70533539 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ж.Болормаа<br>Утас:70533539 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Азуре хүлүг аудит ХХК<br>Утас:70110090 Цахим хаяг:audit@azure.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024.08.15 № 269

танай ________________-ны №________________-т

ХАНБОГД СУМЫН
"ОРГИЛДОРЖШҮГ" ОНӨААТҮГ-ЫН
ЭРХЛЭГЧ Г.УРАНТӨГС ТАНАА

## Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ханбогд сумын "Оргилдоржшүг" ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Ханбогд сумын "Оргилдоржшүг" ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар анхан шатны баримт бүрдэл хангалтгүй, тайлант хугацааны эцэст бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй, өглөгийн үлдэгдлийг буруу илэрхийлсэн 120,113.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгтэй нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд батлагдсан бүтэц орон тоогоор ажилласан байна.

### Аудитын гол асуудал

Орлогыг 170,000.0 мянга, зардлыг 126,715.2 мянган төгрөг байхаар баталж гүйцэтгэлээр 36,671.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн 50,513.9 мянган төгрөг зарцуулж 13,842.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

016020473

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй бусад асуудал байхгүй болно

**.Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Баланс | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| **Хөрөнгө** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 6,149,648.73 | 1,864,037.21 |
| Бараа материал | 75,426,400.48 | 67,676,209.00 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **81,576,049.21** | **69,540,246.21** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Үндсэн хөрөнгө | 2,158,541.54 | 1,682,686.34 |
| Биет бус хөрөнгө | 11,355,000.00 | 11,355,000.00 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **13,513,541.54** | **13,037,686.34** |
| **Нийт хөрөнгийн дүн** | **95,089,590.75** | **82,577,932.55** |
| **Өр төлбөр** | | |
| **Богино хугацаат өр төлбөр** | | |
| Дансны өглөг | - | 3,763,728.00 |
| Татварын өр | 4,031,968.86 | 1,546,788.65 |
| НДШ-ийн өглөг | - | 52,228.81 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **4,031,968.86** | **5,362,745.46** |
| Эздийн өмч | | |
| Өмч : төрийн | 18,358,261.00 | 18,358,261.00 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 4,780,714.47 | 4,780,714.47 |
| Хуримтлагдсан ашиг | 67,918,646.42 | 54,076,211.62 |
| Тайлан үеийн алдагдал | - | (13,842,434.80) |
| **Эздийн өмчийн дүн** | **91,057,621.89** | **77,215,187.09** |
| **Өр төлбөр ба эздийн өмчийн дүн** | **95,089,590.75** | **82,577,932.55** |

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|
| Борлуулалтын орлого | 147,846,340.84 | 36,671,498.16 |
| Борлуулалтын өртөг | 115,181,431.89 | 30,346,116.69 |
| **Нийт ашиг** | **32,664,908.95** | **6,325,381.47** |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 26,463,059.51 | 20,167,816.27 |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **6,207,849.44** | **(13,842,434.80)** |
| Орлогын татварын зардал | 620,784.94 | - |
| **Татварын дараах ашиг (алдагдал)** | **5,581,064.50** | **(13,842,434.80)** |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | - | - |
| **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | **5,581,064.50** | **(13,842,434.80)** |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **14,503,261.00** | **4,780,714.47** | **69,527,718.71** | **88,811,694.18** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 3,855,000.00 | - | (7,190,136.79) | (3,335,136.79) |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **14,503,261.00** | **4,780,714.47** | **62,337,581.92** | **85,476,557.39** |
| Өмчид гарсан өөрчлөлт | 3,855,000.00 | - | - | 3,855,000.00 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 5,581,064.50 | 5,581,064.50 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **18,358,261.00** | **4,780,714.47** | **67,918,646.42** | **91,057,621.89** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **18,358,261.00** | **4,780,714.47** | **67,918,646.42** | **91,057,621.89** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (13,842,434.80) | (13,842,434.80) |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **18,358,261.00** | **4,780,714.47** | **54,076,211.62** | **77,215,187.09** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Тайлант он |
|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **Мөнгөн орлогын дүн (+)** | **162,630,975.02** | **40,326,644.98** |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 162,630,975.01 | 40,326,644.98 |
| **Мөнгөн зарлагын дүн (+)** | **170,301,674.33** | **44,612,256.50** |
| Ажиллагчдад төлсөн | 18,297,325.00 | 12,267,192.00 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 5,303,070.58 | 4,181,067.50 |
| Бараа материалын худалдан авахад төлсөн | 144,933,968.50 | 26,202,397.00 |
| Банкны зардал | 98,000.00 | - |
| Татварын байгууллагад төлсөн | 1,675,310.25 | - |
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн** | **(7,676,699.31)** | **(4,285,611.52)** |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | (7,676,699.31) | (4,285,611.52) |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **13,826,348.04** | **6,149,648.73** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **6,149,648.73** | **1,864,037.21** |

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|
| **Нийт борлуулалт** | **170,000,000.00** | **36,671,498.16** | **133,328,501.84** |
| Борлуулалтын орлого | 170,000,000.00 | 36,671,498.16 | 133,328,501.84 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 30,000,000.00 | 30,346,116.69 | ( 346,116.69) |
| **Нийт зардал** | **126,715,278.00** | **50,513,932.96** | **76,201,345.04** |
| Түүхий эдийн зардал | 65,900,000.00 | - | 65,900,000.00 |
| Ажилчдын цалин | 27,191,760.00 | 13,369,230.57 | 13,822,529.43 |
| НДШ,ЭМД | 3,398,970.00 | 4,181,067.50 | (782,097.50) |
| Элэгдлийн зардал | 224,548.00 | 475,855.20 | (251,307.20) |
| Бусад зардал | - | 2,141,663.00 | (2,141,663.00) |
| **Нийт ашиг** | **43,284,722.00** | **(13,842,434.80)** | **57,127,156.80** |
| Орлогын татвар | 4,328,472.00 | - | 4,328,472.00 |
| **Цэвэр ашиг** | **38,956,250.00** | **(13,842,434.80)** | **52,798,684.80** |

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Мөнгөн зарлагын ажил гүйлгээг шалгахад анхан шатны баримтгүй 44,530.6 мянган төгрөгийн 36 ажил гүйлгээ байна. | 1 | 44,530.6 | - | - | - | - | - | - | 1 | 44,530.6 | 1 | 44,530.6 |
| Бараа материалын түүвэр тооллогоор 895.4 мянган төгрөгийн 25 борлуулсан материалыг бүртгэлийн үлдэгдлээс хасаагүй байна. | 1 | 895.4 | - | - | - | - | - | - | 1 | 895.4 | 1 | 895.4 |
| Бараа материалын дансны 74,066.7 мянган төгрөгийн 175 ажил гүйлгээ нь анхан шатны баримтын иж бүрдлийг хангаагүй байна. | 1 | 74,066.7 | - | - | - | - | - | - | 1 | 74,066.7 | 1 | 74,066.7 |
| Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн 7,078.8 мянган төгрөгийн 31 төрлийн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоогоогүй байна. | 1 | - | - | - | - | - | - | - | 1 | - | 1 | - |
| Үндсэн хөрөнгийн түүвэр тооллогоор 5,360.0 мянган төгрөгийн 7 хөрөнгийн код хийгээгүй, 3,284.4 мянган төгрөгийн 7 хөрөнгө эвдрэлтэй ашиглах боломжгүй нөхцөл байдалтай байсан. | 1 | - | - | - | - | - | - | - | 1 | - | 1 | - |
| Бараа материалын зарлагыг бүртгэлд тусгаагүй байна. | 1 | 7,353.0 | 1 | 7,353.0 | - | - | 1 | 7,353.0 | - | - | - | - |
| Татварын өр төлбөрийн үлдэгдлийг илүү тусган илэрхийлсэн байна. | 1 | 753.6 | - | - | 1 | 753.6 | 1 | 753.6 | - | - | - | - |
| Ерөнхий удирдлагын зардлыг илүү тусган илэрхийлсэн байна. | 1 | 34.0 | - | - | 1 | 34.0 | 1 | 34.0 | - | - | - | - |
| **Дүн** | **8** | **127,633.3** | **1** | **7,353.0** | **2** | **787.6** | **3** | **8,140.6** | **5** | **119,492.7** | **5** | **119,492.7** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тайлант хугацааны эцэст бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй байна. | 1 | - | - | - | 1 | - | - | - | - | - | - | - |
| Аж ахуй нэгжийн орлогын албан татварын өр төлбөрийн үлдэгдэл татварын тодорхойлолтоос 620.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. | 1 | 620.7 | - | - | - | - | 1 | 620.7 | - | - | - | - |
| Улсын бүртгэлийн гэрчилгээ болон санхүүгийн тайлангаар эздийн өмчийн дүн 9,311.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Тус байгууллага нь 170,000.0 мянган төгрөгийн орлого олохоор төлөвлөсөн боловч 36,671.4 мянган төгрөгийн орлого олж батлагдсан төлөвлөгөөг биелүүлээгүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| **Дүн** | **4** | **620.7** | - | - | 1 | - | **3** | **620.7** | - | - | - | - |